



Г

7

“НИЙСЛЭЛИЙН
ТЭЭВРИЙН ГАЗАР”-Т

“ҮНДЭСНИЙ БЕТОН ҮЙЛДВЭРЛЭГЧДИЙН
ХОЛБОО” ТББ

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг 20-р хороо, Үйлдвэрийн
баруун бүс, эрчим хүчиний гудамж ТЭЦ 4 урд өөрийн байр.

Имэйл хаяг: concrete.association@gmail.com
Утас: 9191-6969

2022.09.22 № 02/03

Таны _____ -ны № _____ -т

Г

7

Санал хүргүүлэх тухай

Үндэсний бетон зуурмаг үйлдвэрлэгчдийн холбоо нь Монгол Улсад бетон зуурмагийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлж буй бизнес эрхлэгчдийн нийтлэг эрх ашгийг илэрхийлэн хамгаалах, барилгын салбарын хөгжилд тэргүүлэгч болоход идэвхитэй дэмжигч байх, саад бэрхшээлгүй үйл ажиллагаа явуулахад зохицуулагч гол хүчин болох, бизнесийн өрсөлдөөнт хөгжлийг нийгэм болон эдийн засгийн арга хэмжээгээр дэмжин үйлчилгээ үзүүлэх зорилгот бүхий Төрийн бус байгууллага. Манай салбарын аж ахуйн нэгжүүд Монгол Улсад чанартай барилга, байшин барих, иргэдийн амьдрал суурьших таатай нөхцлийг бүрдүүлэхийн төлөө техник технологи, чанар шаардлагад суурилсан бетон зуурмаг нийлүүлэн идэвхитэй ажилласаар ирсэн.

Бид 2014 онд батлагдсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээвэрлэлтийг зохион байгуулах журам”-г шинэчлэж байгаатай холбогдуулан шинэ журмын төсөлд дараах саналыг хүргүүлж байгааг хүлээн авна уу. Үүнд:

1. ЕС зөвшөөрлийг улирлын чанартай үйл ажиллагаа явуулдагтай уялдуулан хавар 3 сарын 1-с 12 сарын 1 хүртэл ажлын сезондоо 1 удаа авдаг болгох;
2. Улаанбаатар хотод 8м3-р бетон зуурмаг тээвэрлэх боломжтой болгох /6м3-с дээш ачсан тохиолдолд хувь хүн болон хуулийн этгээд гэдгээс хамааран 150.000-1500.000 төгрөгөөр торгож байгаа/;
3. Уулын зам болон Модны 2-н голын зам, Нарантуулын уулзвараас Чулуун овооны тойрог хүртэл, Гурвалжингийн уулзвараас нарны замаар яван зүүн чулуун овооны тойрог хүртэл, Нарантуулын уулзвараас хойшоо зүүн дөрвөн замаар дамжин КТМС-н уулзвар хүртэл тус тус ЕС зөвшөөрлөөр явуулдаг болгох;
4. Улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг тул миксерийг дугаарын хязгаарлалтаас чөлөөлөх;

5. ЕС болон Түр гэсэн хоёр зөвшөөрөл авдаг бус боломжтой бол зөвхөн нэг ЕС зөвшөөрлөө аваад хөдөлгөөнд хориглосон бүсүүдэд оролцож болдог болгох;
6. Түр зөвшөөрөл авахад шаардлагатай дараах материалуудыг бүрдүүлдэг байсныг танах Үүнд:
 - a. Тухайн компанийн хамтарч ажиллаж байгаа гэрээний хуулбар;
 - b. Цагийн хязгаарлалт тогтоосон гудамж замруу зайлшгүй зорчих;
 - c. Шаардлагыг нотлох баримт бичиг /ачаа тээвэрлэлтийн гэрээ гэх мэт/;
 - d. Хамтран ажиллаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын гэрчилгээ, тусгай зөвшөөрөл, ажил эхлүүлэх зөвшөөрлийн хуулбар гэх мэт хэт хувийн шинжтэй компанийн нууцтай холбоотой материалуудыг шаарддагыг болиулах;
7. ЕС зөвшөөрөл авахад "Ачаа тээвэрлэлтийн тайлан"-г явуулдаг нь хэтэрхий нуршуу бүх маршрут бүх ачаа тээврийн талаар гараар шивж өгөхийг шаарддаг ба энэ нь тухайн шивж байгаа хүний уг ажилд хэрхэн хандаж байгаагас үүдэн ачаа тээвэрлэлтийн тайлан статистик мэдээлэл худлаа шивэгдэх магадлалтай ба ихэнх тохиолдолд уг тайлан нь худлаа тайлан байдаг тул шаардлагагүй ажлыг хүмүүсээс хийхийг шаардахыг зогсоох;
8. Замын хөдөлгөөний дүрмийн 24.4т Суурин газарт 22 цагаас 06 цагийн хооронд дуу чимээ гаргаж ачаа ачих буулгахыг хориглоно гэсэн заалт нь Нийтийн тээвэр үйлчилгээний газраас олгодог төв замын С зөвшөөрөл дээр 22 цагаас хойш нэвтрэхийг зөвшөөрсөн байdag нь зөрчилддэг. С зөвшөөрөлд заасан дагуу 22 цагаас хойш зарим зам, хороолол, барилгад цутгалт хийх явцад ЗХД-ийн хууль заалт зөрчсөн гэж оршин суугч, албан байгууллага гомдол гаргаж эргүүлийн цагдаа дуудаж ажил таслалдах тохиолдол гардаг тул аль нэг заалтыг баримтлах зэрэг болно.

Монгол Улсынхаа дэд бүтэц, барилга, хөгжилд дэвшилд хувь нэмрээ оруулж буй бид бүгдийн эрх ашгийг хамгаалах, дэмжлэг үзүүлэн дээрх хүсэлтүүдийн хүлээн авч, шийдвэрлэж өгнө үү.

Бидэнтэй хамтран ажиллана гэдэгт бүрэн итгэлтэй байна. Та бүхэнд ажлын өндөр амжилт хүсье.

ТЭРГҮҮН



А.ХУЛАН